



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/285

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 121 дүгээр  
цэцэрлэгийн данснаас барилга  
байгууламж, нийтийн эзэмшлийн  
эд хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 96 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/708 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2018 оны 02-07-112/1361 дүгээр дүгнэлтийн дагуу Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах, энэ тушаалын хавсралтад заасан 940,949,994.0 /есөн зуун дөчин сая есөн зуун дөчин есөн мянга есөн зуун ерэн дөрвөн/ төгрөгийн үнэ бүхий барилгыг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 121 дүгээр цэцэрлэг /В.Дэлгэрмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 121 дүгээр цэцэрлэг /В.Дэлгэрмаа/-т даалгасугай.

3. Хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой материалыг хөндлөнгийн үнэлгээний байгууллагын үнэлсэн 4,050,800.0 /дөрвөн сая тавин мянга найман зуун/ төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхийг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтан	Хэмжи	Тоо	Нийт үнэ	Байгуулсан элгдэл	Үлдэгдэл үнэ /2019.03.31/
1	Цэцэрлэгийн барилга	1976	ш	1101	794,808,000	493,145,039.55	301,662,960.45
2	Дулааны шугам	1973	у/м	230	72,220,000	72,220,000	-
3	Бохрын шугам	1990	у/м	70	4,900,000	4,900,000	-
4	Цэвэр усны шугам	1990	у/м	230	10,580,000	10,580,000	-
5	Дээрний засвар	2010			14,000,000	1,545,101.52	12,454,898.48
6	Барилгын засвар	2013			42,307,626	8,814,089	33,493,537
7	Бетондсон талбай	1973			800,000	800,000	-
8	Толгоомын талбай	1973	ш	1	1,288,168	1,288,168	-
9	Мод, бут	1973	ш	6	46,200	-	46,200
НИЙТ ДҮН					940,949,994	593,292,398.1	347,657,595.9

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ  
 БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, НИТИЙН ЭЗЭМШИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСГАЛТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны дугаар сарын 31-ийн өдрийн 2019/03.31/ дугаар тушаалын хавсралт

